



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 03 сарын 06 өдөр

Дугаар А/123

Есөнбулаг сум

Хил хамгаалалтын торон
саад байгуулах ажлын эрх шилжүүлэх
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 60.1.5 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 14.4 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.3 дахь заалт, Монгол Улсын Хилийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1.1, 50.1.2 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 64 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн 203,342,000 (хоёр зуун гурван сая гурван зуун дөчин хоёр мянга) төгрөгийн хөрөнгө оруулалтаар “Хил хамгаалалтын торон саад байгуулах ажлын” гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гүйцэтгүүлэх эрхийг Хилийн цэргийн 0214 дүгээр ангийн захирагч (хурандаа Э.Майдар)-д шилжүүлсүгэй.

2. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийн дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулж, шаардлага хангасан гүйцэтгэгчтэй гэрээ байгуулан, захиалагч, гүйцэтгэгчийн хяналт, хариуцлагыг гэрээнд тодорхой тусгаж, хэрэгжилтэд хяналт тавьж, тайлагнаж ажиллахыг Хилийн цэргийн 0214 дүгээр ангийн захирагч (хурандаа Э.Майдар)-д үүрэг болгосугай.

3. Ажлын гүйцэтгэл, чанар, санхүүжилт, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Д.Чинзориг)-д Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Д.Буянхишиг)-т, Хууль, эрх зүйн хэлтэс (Н.Эрдэнэ-Очир)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ